



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Эрдэнэт хот  
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Эрдэнэ  
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn  
Аудитор: Б.Азжаргал  
Утас: 70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	12
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа .....	16
4.4 Зөвлөмж .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 110  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗДТГ-ЫН  
ДАРГА Т.ЭНХЖАРГАЛ ТАНАА

#### Аудитын санал дүгнэлт

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Аудитын гол асуудал:

Шинэ жилийн үеэр нийт ажилчдад 532.0 мянган төгрөгийн оргилуун дарс олгосон, Засгийн газрын тогтоол зөрчин зочин төлөөлөгч хүлээн авах зардлаас 25,790.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 36,222.0 мянган төгрөгийн өр төлбөр барагдуулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зах зээлийн үнээс

D:\my doc\alban bichigt\2022-A4.doc

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл аудитлагдсан	Эцсийн үлдэгдэл аудитлагдсан
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	456,878,687.00	438,728,291.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,405,150.00	955,150.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,405,150.00	955,150.00
31110	Төгрөг	1,405,150.00	955,150.00
33	АВЛАГА	265,721,941.00	212,163,541.30
3351	Байгууллагаас авах авлага	57,371,441.00	3,813,041.30
3352	Хувь хүмүүсээс авах авлага	208,350,500.00	208,350,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	189,751,596.00	225,609,600.00
351	Түүхий эд материал	63,287,800.00	88,219,600.00
35110	Тусгай зориулалттай материал	63,287,800.00	88219600
354	Хангамжийн материал	56,916,000.00	107,390,000.00
35410	Бичиг хэргийн материал	230,000.00	-
35420	Аж ахуйн материал	56,000.00	-
35600	Мал амьтад	56,630,000.00	107,390,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	69,547,796.00	30,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,907,268,205.87	4,784,679,350.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,907,268,205.87	4,784,679,350.42
392	Биет хөрөнгө	4,880,407,650.33	4,758,407,128.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,468,898,753.05	4,619,975,681.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,112,131,545.49)	(1,338,239,726.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	564,654,864.00	610,854,864.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(287,668,064.44)	(338,804,543.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	628,200,274.08	688,781,918.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(516,398,238.40)	(533,317,538.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	386,968,369.61	385,919,332.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	(231,368,116.09)	(263,564,248.10)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,782,865,016.52	1,975,179,403.52
39215	Хуримтлагдсан элэгдэл	(813,613,662.51)	(1,058,378,014.18)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	10,000,000.00	10,000,000.00
393	Биет бус хөрөнгө	26,860,555.54	26,272,222.18
39301	Програм хангамж	3,564,000.00	3,564,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,723,444.46)	(2,311,777.82)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,020,000.00	25,020,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,364,146,892.87	5,223,407,641.72
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	117,260,295.09	40,535,207.24
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	117,260,295.09	40,535,207.24
413	Өглөг	117,260,295.09	40,535,207.24
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	180,474.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	27,531,784.00	3,813,041.30
4136	Бусад өглөг	89,548,037.09	36,722,165.94
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,246,886,597.78	5,182,872,434.48

**Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	704,130,855.63	704,130,855.63
	Дахин үнэлгээний нөөц	1,197,433,550.16	1,197,433,550.16
512	Хуримтлагдсан үр дүн	3,345,322,191.99	3,281,308,028.69
51210	Өмнөх үеийн үр дүн	3,345,322,191.99	3,345,322,191.99
51220	Тайлант үеийн үр дүн		(64,014,163.30)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,364,146,892.87	5,223,407,641.72

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	АУДИТЛАГДААГҮЙ	АУДИТЛАГДСАН
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,331,360,312.65	3,331,360,312.65
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,357,160,237.14	1,357,160,237.14
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,305,701.00	4,305,701.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,576,733.00	18,576,733.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,334,277,803.14	1,334,277,803.14
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	815,908,975.51	815,908,975.51
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	502,144,809.00	502,144,809.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,585,516.00	5,585,516.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	308,178,650.51	308,178,650.51
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,158,291,100.00	1,158,291,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,158,291,100.00	1,158,291,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,386,949,475.83	3,386,949,475.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,386,949,475.83	3,386,949,475.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	626,485,816.28	626,485,816.28
210101	Үндсэн цалин	470,147,898.31	470,147,898.31
210102	Нэмэгдэл	134,388,424.04	134,388,424.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,429,895.75	20,429,895.75
210105	Гэрээт ажлын хөлс	1,519,598.18	1,519,598.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,107,182.46	84,107,182.46
210201	Тэтгэврийн даатгал	62,599,782.46	62,599,782.46
210202	Тэтгэмжийн даатгал	5,711,200.00	5,711,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,407,700.00	4,407,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,072,000.00	1,072,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,316,500.00	10,316,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	350,586,293.06	350,586,293.06
210301	Гэрэл, цахилгаан	51,796,599.28	51,796,599.28
210302	Түлш, халаалт	294,050,004.82	294,050,004.82
210303	Цэвэр, бохир ус	4,739,688.96	4,739,688.96

**Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2104	Хангамж, бараа материалын зардал	242,602,021.00	242,602,021.00
210401	Бичиг хэрэг	19,529,950.00	19,529,950.00
210402	Тээвэр, шатахуун	116,982,966.00	116,982,966.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,972,605.00	5,972,605.00
210404	Ном, хэвлэл	2,300,000.00	2,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	65,509,500.00	65,509,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,307,000.00	32,307,000.00
2105	Нормативт зардал	5,588,900.00	5,588,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,588,900.00	5,588,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	908,473,005.54	908,473,005.54
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,240,000.00	1,240,000.00
210602	Тавилга	2,306,000.00	2,306,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,784,500.00	4,784,500.00
210604	Урсгал засвар	900,142,505.54	900,142,505.54
2107	Томилолт, зочны зардал	40,000,000.00	40,000,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	40,000,000.00	40,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	312,574,902.62	312,574,902.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	309,083,574.62	309,083,574.62
210803	Даатгалын үйлчилгээ	1,094,850.00	1,094,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340,030.00	340,030.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	297,000.00	297,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	259,448.00	259,448.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	737,532,376.25	737,532,376.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,551,431.78	125,551,431.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,600,000.00	9,600,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	602,380,944.47	602,380,944.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,270,580.73	52,270,580.73
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,519,000.00	23,519,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,096,100.00	9,096,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,655,480.73	19,655,480.73
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,728,397.89	26,728,397.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,728,397.89	26,728,397.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(55,589,163.18)	(55,589,163.18)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,425,000.12	8,425,000.12
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	195,000.12	195,000.12
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	8,230,000.00	8,230,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(8,425,000.12)	(8,425,000.12)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(64,014,163.30)	(64,014,163.30)

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

АУДИТЛАГДЛАГДСАН					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	704,130,855.63	1,197,433,550.16	3,345,322,191.99	5,246,886,597.78
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	704,130,855.63	1,197,433,550.16	3,345,322,191.99	5,246,886,597.78
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	704,130,855.63	1,197,433,550.16	3,345,322,191.99	5,246,886,597.78
D08	Тайлант үеийн үр дүн			(64,014,163.30)	(64,014,163.30)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	704,130,855.63	1,197,433,550.16	3,281,308,028.69	5,182,872,434.48

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	АУДИТЛАГДААГҮЙ	АУДИТЛАГДСАН
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,046,257,383.51	2,053,179,329.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,305,701.00	4,305,701.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,305,701.00	4,305,701.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	883,660,582.51	883,660,582.51
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	532,774,975.00	532,774,975.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,585,516.00	5,585,516.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	345,300,091.51	345,300,091.51
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,158,291,100.00	1,158,291,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,158,291,100.00	1,158,291,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	6,921,945.63
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	6,921,945.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,955,379,861.51	1,967,907,757.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,955,379,861.51	1,967,907,757.14

**Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	626,666,290.28	626,666,290.28
210101	Үндсэн цалин	470,328,372.31	470,328,372.31
210102	Нэмэгдэл	134,388,424.04	134,388,424.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,429,895.75	20,429,895.75
210105	Гэрээт ажлын хөлс	1,519,598.18	1,519,598.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,107,182.46	84,107,182.46
210201	Тэтгэврийн даатгал	62,599,782.46	62,599,782.46
210202	Тэтгэмжийн даатгал	5,711,200.00	5,711,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,407,700.00	4,407,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,072,000.00	1,072,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,316,500.00	10,316,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	382,816,245.06	382,816,245.06
210301	Гэрэл, цахилгаан	51,796,599.28	51,796,599.28
210302	Түлш, халаалт	326,279,956.82	326,279,956.82
210303	Цэвэр, бохир ус	4,739,688.96	4,739,688.96
2104	Хангамж, бараа материалын зардал	205,670,371.00	205,670,371.00
210401	Бичиг хэрэг	19,970,800.00	19,970,800.00
210402	Тээвэр, шатахуун	83,803,166.00	83,803,166.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,729,405.00	5,729,405.00
210404	Ном, хэвлэл	2,300,000.00	2,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	61,560,000.00	61,560,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,307,000.00	32,307,000.00
2105	Нормативт зардал	9,748,400.00	9,748,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,748,400.00	9,748,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	165,031,611.39	171,137,561.39
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,300,000.00	5,300,000.00
210602	Тавилга	1,768,300.00	7,874,250.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,800,000.00	5,800,000.00
210604	Урсгал засвар	152,163,311.39	152,163,311.39
2107	Томилолт, зочны зардал	40,000,000.00	40,000,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	40,000,000.00	40,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	303,484,597.40	303,484,597.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	299,993,269.40	299,993,269.40
210803	Даатгалын үйлчилгээ	1,094,850.00	1,094,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	340,030.00	340,030.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	297,000.00	297,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	259,448.00	259,448.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,043,144.00	55,043,144.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,443,144.00	45,443,144.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,600,000.00	9,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,270,580.73	59,192,526.36
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	6,921,945.63

**Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,519,000.00	23,519,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,096,100.00	9,096,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,655,480.73	19,655,480.73
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,813,041.30	3,313,041.30
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	-	(500,000.00)
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,813,041.30	3,813,041.30
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,728,397.89	26,728,397.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,728,397.89	26,728,397.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	90,877,522.00	85,271,572.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	91,827,522.00	85,721,572.00
223001	Бусад хөрөнгө	91,827,522.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	85,721,572.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(91,827,522.00)	(85,721,572.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(950,000.00)	(450,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,405,150.00	1,405,150.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	455,150.00	955,150.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны / төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,173,267,100.00	1,164,518,369.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,173,267,100.00	1,098,678,931.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,138,955,500.00	1,073,102,327.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	576,762,600.00	576,762,600.00
210101	Үндсэн цалин	482,475,000.00	486,094,232.43
210102	Нэмэгдэл	47,765,200.00	46,708,226.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,388,000.00	3,388,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	43,134,400.00	40,572,141.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,862,900.00	77,862,900.00
210201	Тэтгэврийн даатгал	54,792,400.00	54,792,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,767,600.00	5,767,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,614,100.00	4,614,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,153,500.00	1,153,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,535,300.00	11,535,300.00

**Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,993,300.00	80,980,724.50
210301	Гэрэл, цахилгаан	20,900,000.00	20,900,000.00
210302	Түлш, халаалт	55,698,000.00	55,685,432.00
210303	Цэвэр, бохир ус	4,395,300.00	4,395,292.50
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	139,194,600.00	139,194,600.00
210401	Бичиг хэрэг	8,100,000.00	8,100,000.00
210402	Тээвэр, шатахуун	43,460,000.00	43,460,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,845,300.00	5,845,300.00
210404	Ном, хэвлэл	2,300,000.00	2,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	69,489,300.00	69,489,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,000,000.00	10,000,000.00
2105	Нормативт зардал	3,500,000.00	3,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000.00	3,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	153,015,000.00	87,755,412.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	40,000,000.00	40,000,000.00
210602	Тавилга	15,000,000.00	3,505,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,800,000.00	1,799,850.00
210604	Урсгал засвар	96,215,000.00	42,450,462.00
2107	Томилолт, зочны зардал	3,800,000.00	3,800,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	3,800,000.00	3,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,365,600.00	73,784,591.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,656,400.00	69,076,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,209,600.00	1,209,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	843,500.00	843,048.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	610,100.00	610,095.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	286,000.00	286,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	260,000.00	259,448.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,461,500.00	29,461,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,861,500.00	19,861,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,600,000.00	9,600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,311,600.00	25,576,604.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,311,600.00	25,576,604.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	(5,403,841.00)
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	300,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,207,600.00	11,776,612.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,804,000.00	19,203,833.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	65,839,437.85
2200	Дотоод эх үүсвэрээр	-	65,839,437.85
223001	Бусад хөрөнгө	-	65,839,437.85
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,167,863,259.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	1,170,816,750.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	1,170,816,750.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	(5,403,841.00)
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	(5,403,841.00)

**Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	2,450,350.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,450,350.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,405,150.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		955,150.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	406,454,340.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	349,640,024.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	335,288,824.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,629,310.43
210101	Үндсэн цалин	40,010,078.00
210102	Нэмэгдэл	1,056,973.43
210105	Гэрээт ажлын хөлс	2,562,259.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,288,491.57
210201	Тэтгэврийн даатгал	4,288,491.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,485,263.00
210301	Гэрэл, цахилгаан	9,561,614.00
210302	Түлш, халаалт	76,208,216.00
210303	Цэвэр, бохир ус	9,715,433.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,199,700.00
210401	Бичиг хэрэг	1,999,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,285,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	774,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,140,000.00
2105	Нормативт зардал	4,887,528.00
210502	Хоол, хүнс	4,887,528.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,730,873.00
210602	Тавилга	37,791,000.00
210604	Урсгал засвар	25,939,873.00
2107	Томиллолт, зочны зардал	314,000.00
210702	Дотоод албан томиллолт	314,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,514,658.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,514,658.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,239,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,239,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,351,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,351,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,351,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,814,316.00
2200	Дотоод эх үүсвэрээр	56,814,316.00
223001	Бусад хөрөнгө	56,814,316.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	431,833,997.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	431,833,997.00

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,878,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	349,703,169.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,251,928.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азжаргал гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 03/44 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж, чадамжинд суурилсан мэргэшсэн нутгийн захиргааны байгууллага байх, төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар төрийн албан хаагчдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн чадварлаг захиргааны байгууллага болох эрхэм зорилго бүхий Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХууль тогтоомжид өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн, төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв болох 2,057,593.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 20,575.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 14,403.15 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад өөрчлөөгүй болно.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын Засаг даргын Тамгийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140,739.2 мянган төгрөгөөр буюу (2.7) хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,405.1	955.1	(450.0)
Бараа материал	120,203.8	195,609.6	75,405.8
Үндсэн хөрөнгө	4,907,268.2	4,784,679.4	(122,588.8)
Авлага	265,721.9	212,163.5	(53,558.4)
Нөөцийн бараа	69,547.8	30,000	(39,547.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,364,146.80</b>	<b>5,223,407.60</b>	<b>(140,739.20)</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,246,886.5	5,182,872.4	(64,014.1)
Өр төлбөр	117,260.3	40,535.2	(76,725.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,364,146.8</b>	<b>5,223,407.6</b>	<b>(140,739.2)</b>

Бараа материалын данс 195,609.6 мянган төгрөг болж 75,405.8 мянган төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 45,405.8 мянган төгрөгөөр мал амьтад, сумын өвс тэжээлийн фондод 30,000.0 мянган төгрөгөөр өвс тэжээл худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,784,679.4 мянган төгрөг болж 122,588.8 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгөөр 17,996.7 мянган төгрөгийн, улсын тэргүүний сумын шагналаар 20,724.8 мянган төгрөгийн, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 150,913.7 мянган төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сангаас 59,100.3 мянган төгрөгийн, сумын ОНХСангийн хөрөнгө оруулалтаар 156,362.7 мянган төгрөгийн, сумын ЕБС-аас 74,888.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгүүд бэлтгэгдэж ирсэн ба 36,623.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актласан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,677,086.3 мянган төгрөгөөр төлөвлөн, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэнээс 1,173,267.1 мянган төгрөгөөр батлагдан ирсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,168,961.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, төсөвт байгууллагын өөрийн орлого 4,305.7 мянган төгрөгийн нийт 1,173,267.1 мянган төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 1,164,518.7 мянган төгрөгийг тайлант онд зарцуулсан байна.

Үүнээс: цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 521,478.1 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 72,031.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 94,864.8 мянган төгрөг, хангамжийн материалын зардалд 146,183.9 мянган төгрөг, норматив зардал 4,750.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 65,267.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 5,491.3 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 52,088.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардалд 48,245.1 мянган төгрөг зарцуулсан ба хэмнэгдсэн зардал болох нийт 26,728.3 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд уурын зуухны халаалтын 318,186.1 мянган төгрөгийн, хүүхдийн автобусны 22,221.4 мянган төгрөгийн, статистикийн газраас 5,585.5 мянган төгрөгийн, тендерийн орлого 1,302.0 мянган төгрөгийн, шилдэг сумын шагналын

25,339.6 мянган төгрөгийн, аймгийн Засаг даргын нөөц сангаас 4,800.0 мянган төгрөгийн, Эрдэнэт сангаас 15,750.0 мянган төгрөгийн, аймгаас эрх шилжүүлэх 451,862.0 мянган төгрөгийн, Засгийн газраас хог хаягдалын үйлчилгээний хураамж 276.1 мянган төгрөгийн, Гэр бүл хүүхэд залуучуудын холбооноос 300.0 мянган төгрөгийн, ОБГазраас 37,841.5 мянган төгрөгийн санхүүжилт авч төслийн заалт, зорилго, зорилтын дагуу царцуулсан бөгөөд 3,813.0 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлж авлагаар тусгаж өгсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 3 мэдээлэл огт оруулаагүй, 34 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 3 мэдээлэл огт оруулаагүй, 34 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн харин зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн е-баримтгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангаагүй ажил гүйлгээ хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг

зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Шилэн дансны тухай хуулийн 6.1-д энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д “заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 108,758.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 72,053.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, 150.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, 36,554.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	3	36,554.9	2	332.9	1	36,222.0	
Албан шаардлага	1	72,053.5	1	72,053.5			
Төлбөрийн акт	1	150.0	1	150.0			
Нийт дүн	5	108,758.4	5	72,536.4	1	36,222.0	

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 110,067.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 34,429.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 532.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 69,249.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 албан шаардлага, 5,856.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

#### 4.1 Залруулсан алдаа

Зардлын зүйл ангийг буруу сонгосоноор санхүүгийн үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд 34,429.7 мянган төгрөгийн залруулга хийв.

#### 4.2 Төлбөрийн акт

##### 1.1. Илрүүлэлт:

Шинэ жилийн үеэр нийт ажилчдад 532.0 мянган төгрөгийн оргилуун дарс олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн

ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7.9-д "төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

#### **4.3 Албан шаардлага**

##### **1.2. Илрүүлэлт:**

Засгийн газрын тогтоол зөрчин зочин төлөөлөгч хүлээн авах зардлаас 25,790.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

##### **1.3. Илрүүлэлт:**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 36,222.0 мянган төгрөгийн өр төлбөр барагдуулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

##### **1.4. Илрүүлэлт:**

Зах зээлийн үнээс 2,457.0 мянган төгрөгийн өндөр үнээр хөрөнгө худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

##### **1.5. Илрүүлэлт:**

Нийт ажилчдын дунд "Багийн оролцоо-Бидний амжилт", "Миний ажил-Бидний амжилт" сэдвийн хүрээнд илтгэлийн уралдаан зарлан, улмаар тушаал гарган 10-40 хувиар буюу 4,780.1 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

#### **2.1. Илрүүлэлт:**

Зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 5,856.4 мянган төгрөгийн дутуу баримтаар гүйлгээ хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан

ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

**2.3. Илрүүлэлт:**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 3 мэдээлэл огт оруулаагүй, 34 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-д "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**2.4. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд, иж бүрэн, шуурхай мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын ЗДТГ	8	110,067.2	1	34,429.7	1	532.0	4	69,249.1	2	5,856.4